

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН 2018 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч танаа

“ЛэндМН ББСБ” хувьцаат компанийн хамт олон өнгөрсөн улиралд шаргуу, хичээн ажиллаж эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигчигчдээ тайлагнах олон сайхан ололт амжилтуудтайгаар 2 дугаар улирлаа үдлээ. Ийнхүү та бүхэнд “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны 2 улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт харилцагчдын тоо 2018 оны 2-р улирлын эцэст **54,919**-д хүрч, өмнөх улирлаас **36%**-аар өслөө. Өнгөрсөн улиралд нийт **32.7** тэрбум төгрөгийн **175.3** мянган зээл олгосноор өмнөх **1** дүгээр улиралтай харьцуулахад **48%**-аар өссөн үзүүлэлттэй байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2 дугаар улирлын **нийт орлого 1 тэрбум 522 сая** төгрөг болж, өмнөх улиралтай харьцуулахад **38%**-аар өслөө. Нийт **цэвэр ашгийн хэмжээ эхний хагас жилд 1 тэрбум 241 сая** төгрөгт хүрсэн ба **2 дугаар улирлын цэвэр ашгийн хэмжээ** өмнөх улирлаас **62%-аар өсч 766.6 сая** төгрөг байна. Тоо үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүйг санхүүгийн тайлангаас харна уу.

ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН 2018 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2018 оны 1-р улирал	2018 оны 2-р улирал
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,421,027	3,109,672
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	7,638,760	10,235,122
Бусад хөрөнгө	8,733	279,211
Үндсэн хөрөнгө	167,558	252,943
Биет бус хөрөнгө	263,503	256,345
Нийт хөрөнгө	12,499,582	14,133,293
Богино хугацаат хаалттай бондын өглөг	1,000,000	2,000,000
Богино хугацаат бусад өглөг	249,585	116,632
Нийт өр төлбөр	1,249,585	2,116,632
Хувьцаат капитал	11,000,000	11,000,000
Хувьцаа нэмж гаргахтай холбоотой шууд зардал**	(243,141)	(243,141)
Хуримтлагдсан ашиг	493,138	1,259,803
Нийт эздийн өмч	11,249,997	12,016,662
Нийт өр төлбөр болон эздийн өмч	12,499,582	14,133,294

**НББОУС 32, Санхүүгийн Тайлан: Тодруулга-н дагуу, хувьцаа нэмж гаргахтай холбоотой зарим зардлуудыг өмчийн хэсэгт бүртгэсэн. Үүнд: андеррайтерын үйлчилгээний хөлс, үнэт цаасны арилжааны шимтгэл гэх мэт орсон. Бусад холбогдох зардлуудыг орлого, үр дүнгийн тайланд зардлаар бүртгэсэн.

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2018 оны 1-р улирал	2018 оны 2-р улирал	2018 оны эхний хагас
Шимтгэл болон түүнтэй адилтгах орлого	1,135,435	1,587,871	2,723,306
Хүүгийн зардал	(44,055)	(46,137)	(90,192)
Цэвэр орлого	1,091,380	1,541,734	2,633,114
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	(46,890)	(53,243)	(100,133)
Үйл ажиллагааны цэвэр орлого	1,044,490	1,488,491	2,532,981
Удирдлага болон үйл ажиллагааны зардал	(433,267)	(637,278)	(1,070,545)
IPO-той холбоотой нэг удаагийн зардал	(79,610)	-	(79,610)
Нийт зардал	(512,876)	(637,278)	(1,150,154)
Татварын өмнөх ашиг	531,613	851,213	1,382,826
Татварын зардал	(57,014)	(84,549)	(141,563)
Цэвэр ашиг	474,599	766,664	1,241,263

ЛэндМН ББСБ ХК-ийн тухай

Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан Финтек бизнес моделийг LendMN аппликейшнээр дамжуулан амжилттай нэвтрүүлж буй барьцаагүй хямд өртөгтэй, хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага юм.

Холбоо барих:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Ч. Намираа
Утас: 9900-3223, Имэйл: contact@lend.mn, board@lend.mn



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН 2018 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

“ЛэндМН ББСБ ХК” нь хувьцаат компани болон өөрчлөгдөн зохион байгуулагдаж, 2018 оны 3 дугаар сард олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалснаас хойш хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаа 2018 оны 5 сарын 9-ний өдөр Тусгаар тогтнолын ордонд албан ёсоор зохион байгуулсан билээ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 87.5% нь биечлэн оролцож, Компанийн засаглалын үндсэн баримт бичиг болох нээлттэй хувьцаат компанийн дүрмээ баталж, компанийн гүйцэтгэх удирдлагын багийг бодлогын удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй шинээр томилж, гишүүдийг сонголоо.

Хувь нийлүүлэгчдийн хурлаас шинээр сонгогдсон анхны хурал 2018 оны 6 сарын 4-ний өдөр хуралдан дотоод журмаа баталж, О.Болдбаатарыг ТУЗ-ийн даргаар томилж, ТУЗ-ийн дэргэдэх 3 хороог байгуулах шийдвэрийг гаргалаа. Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр Баянжаргалын Дэлгэржаргалыг “ЛэндМН ББСБ ХК”-ийн гүйцэтгэх захирлаар сонгон шалгаруулж, томиллоо. Б. Дэлгэржаргал нь банк, санхүүгийн салбарт 26 жил ажилласан арвин туршлагатай мэргэжилтэн юм.



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал: 2018.05.09




“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн хурал: 2018.06.04

“ЛэндМН ББСБ ХК”-ийн ТУЗ-ийн хурлаар компанийн үйл ажиллагааны өсөлтийг хангах зорилгоор зээлийн үндсэн бүтээгдэхүүний санхүүжилтийн шинэ үүсвэрт зориулан нийт **5.0 тэрбум** төгрөгийн хаалттай бондыг **2, 3** дугаар улиралд гаргах шийдвэрийг гаргаж, үүнээс **1.0 тэрбум** төгрөгийн хаалттай бондыг 2018 оны 6 сарын 18-ны өдөр гарган, эх үүсвэрийг татан төвлөрүүлээд байна.

ЛэндМН хувьцаа 2018 оны 3 сарын 14-ний өдөр хоёрдогч зах зээлд арилжаалагдаж эхэлснээс хойш хөрвөх чадвар, арилжаалагдсан хувьцааны тоо ширхэг, үнийн дүн зэргээрээ Монголын Хөрөнгийн Биржийн үзүүлэлтүүдийг тэргүүлж 2018 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар нэгж хувьцааны ханш **56.40** төгрөгт хүрч, анхдагч зах зээлд санал болгосон **25.00 төгрөгөөс 126%** -аар өссөн байна.

ЛэндМН хувьцааны ханшийн график: /MSE: LEND/




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж




“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН 2018 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН


Биржийн нэг өдрийн нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь (2 улирал)



Биржийн нэг өдрийн нийт арилжсан хувьцааны тоо ширхэгт эзлэх хувь (2 улирал)



Нэг өдрийн дундаж арилжааны дүн (2-р улирал, сая.төг)



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Борлуулалтын баг орон нутагт ажиллав

“ЛэндМН ББСБ ХК” өнгөрсөн улиралд **400,000** дахь зээлээ олгож, **50,000** дахь хэрэглэгчээ бүртгэн авч дуудлагын төвөөрөө дамжуулан үйлчилгээ үзүүлсэн хэрэглэгчийн тоо **116,000**-д хүрлээ. Орон нутагт борлуулалтын цар хүрээгээ тэлэн Дархан, Сэлэнгэ, Эрдэнэт, Мөрөн, Багануур хотуудад шууд борлуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, **10,000** гаруй хүнд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцууллаа.

Бид ЛэндМН аппликейшнээ харилцагчдынхаа хэрэглээ, хүсэлт, шаардлагад нийцүүлэн улам хялбар, энгийн болгох нэмэлт сайжруулалтуудыг хийсээр байна. Тухайлбал, шинээр хэрэглэгч бүртгэх процессыг хялбар болгосноор хэрэглэгч **2 минутаас** хэтрэхгүй хугацаанд бүртгэлээ хийх боломжтой боллоо. Төрийн мэдээлэл солилцооны **ХУР** системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр хэрэглэгчдийг бүртгэх ажиллагаа боловсронгуй болоод байна.

Зээлийн дээд хэмжээгээ **2,000,000** төгрөг болгож өсгөсөн нь санхүүгийн сахилга бат өндөр, үнэнч хэрэглэгчдээ урамшуулсан хөтөлбөр болсон юм.

“ЛэндМН ББСБ” ХК нь Цахим төлбөр тооцоо санхүүгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авлаа. Ингэснээр зээлийн үйлчилгээнээс гадна ЛэндМН аппликейшнаар дамжуулан **төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга** хийх зэрэг шинэ үйлчилгээгээнүүдийг хурдан, хялбар гүйцэтгэх боломжтой болж байна. ЛэндМН-ийн хөгжүүлэлтийн багийнхан цахим төлбөр тооцооны шинэ шийдэл дээр төвлөрөн ажиллаж хэрэглэгчиддээ хүргэхэд бэлэн болоод байна.

ЛэндМН ББСБ ХК-ийн тухай

Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан Финтек бизнес моделийг LendMN аппликейшнээр дамжуулан амжилттай нэвтрүүлж буй барьцаагүй хямд өртөгтэй, хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага юм.

Холбоо барих:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Ч. Намираа
Утас: 9900-3223, Имэйл: contact@lend.mn, board@lend.mn

